



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 5/47

Хэрлэн сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Нацагдорж нь 2017 оны 03 сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн тул тус сургуулийн багш Б.Анхбаярыг мөн өдрөөс эхлэн сургуулийн захирал томилогдох хүртэл захирлын үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /О.Лхагвадорж/-д даалгасугай.

Гурав. Л.Нацагдоржтой холбогдох тооцоог хийж, дуусган захирлын ажлыг хавсран гүйцэтгэх Б.Анхбаярт үндсэн цалингаас 40 хүртэл хувиар тооцож олгохыг сургуулийн нягтлан бодогч /Б.Оргодол/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА